



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2021 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 510

Улаанбаатар хот

Тарифт өөрчлөлт оруулах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2, 25 дугаар зүйлийн 25.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн “Диспетчерийн үндэсний төв” ХХК-иас ирүүлсэн хүсэлтийг хянан хэлэлцээд Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Тариф батлах тухай” 55 дугаар тогтоолын хавсралтын 1 дүгээр мөрөнд “3,507,948,0” гэснийг “4,414,022.2”, 2 дугаар мөрөнд “1,834,247.7” гэснийг “2,271,240.5”, 3 дугаар мөрөнд “518,392.8” гэснийг “738,856.5” гэж, 4 дүгээр мөрөнд “576,614.6” гэснийг “858,271.6” мянган төгрөг болгож тус тус өөрчилсүгэй.

2. Энэхүү өөрчлөгдсөн диспетчерийн зохицуулалтын үйлчилгээний төлбөр буюу тарифыг 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийг дуустал хугацаанд мөрдөж ажиллахыг “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК (Г.Балжинням), “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК (Р.Дагдан), “Эрдэнэт, Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК (В.Адъяа), “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК (Н.Мөнгөнхөлөгт), “Дархан сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК (Ц.Хангай)-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ тариф, зах зээлийн газар (Б.Болор-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

А.ТЛЕЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ

Э.ТҮВШИНЧУЛУУН

ЗОХИЦУУЛАГЧ

Б.БАТТУЛГА

ЗОХИЦУУЛАГЧ

У.МЯГМАРСҮРЭН

ЗОХИЦУУЛАГЧ

Э.САМДАН